



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/55

Хөхөө

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын  
үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн А/160 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг тооллого, бүртгэлийг зохион байгуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: З.Анхсанчир – Засаг даргын Орлогч дарга

Гишүүд: П.Оргил – Шивэрт багийн засаг дарга

З.Мөнхбат – Ёлгос багийн засаг дарга

Н.Эрдэнэбаяр – Улаан-Асга багийн засаг дарга

З.Дашням – Хөхөө багийн засаг дарга

Ц.Гансүх – Хайрхан толгой багийн засаг дарга

М.Буяннэмэх – Хэсгийн төлөөлөгч

Г.Бямбадорж – Хэсгийн цагдаа

Д.Болд-Эрдэнэ – Санхүү албаны дарга

Нарийн бичгийн дарга: С.Оюундарь – Татварын улсын байцаагч

2.Суманд тээврийн хэрэгслийн үзлэг тооллогыг 2024 оны 06-р сарын 19, 20-ны өдрүүдэд бэлтгэл ажлыг ханган, тээврийн хэрэгслийг бүрэн хамруулахыг комисст даалгасугай.

3.Аймгийн засаг даргын 2024 оны 04-р сарын 08-ны өдрийн А/160 дугаар захирамжаар сумдын салбар комисст даалгасан ажлуудыг хийж гүйцэтгэхийг комисс (З.Анхсанчир)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтийг 2024 оны 07-р сарын 01-ний дотор Засаг даргад танилцуулахыг комисс (З.Анхсанчир)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ